



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 01/10

Улаанбаатар хот

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг боловсронгуй болгох, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хорооны 2024 оны 04 дүгээр тогтооюор байгуулагдсан ажлын хэсгийн санал дүгнэлтийг үндэслэн Ёс зүй, дэгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт, Монгол Улсын Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хороодын бие даасан, хараат бус ажиллах нөхцөлийг хангах эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Ёс зүйн хороо (Ц.Амартөгс)-нд даалгасугай:

1/Төрийн албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн талаарх сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үр дүнтэй, тасралтгүй зохион байгуулж, үнэлэх;

2/ Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагаа, сургалтын төлөвлөлт, тайлагнал, гомдол, мэдээлэл, зөрчил, хариуцлагын нэгдсэн бүртгэлийн системийг сайжруулж, тогтмол хэрэглээг хэвшүүлэх;

3/Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн талаарх сургалтын агуулга, хөтөлбөрт нийцсэн цахим болон танхимын сургалтын гарын авлага, хэрэглэгдэхүүн боловсруулах үйл ажиллагааг мэргэшил, арга зүйн удирдлагаар хангаж, зохион байгуулах;

4/Төрийн албан хаагчийн ёс зүйн талаарх судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлэх, үр дүнг тайлагнах;

5/Мэргэжлийн Ёс зүйн дүрэм, давхардал, хийдлийг арилгах арга хэмжээг эрчимжүүлэх, тусгай чиг үүргийн байгууллагын Ёс зүйн дэд хороог хэрхэн зохион байгуулах талаар судалж, санал боловсруулах;


6/Салбар болон мэргэжлийн ёс зүйн чиглэлээр хууль тогтоомжийн судалгаа хийлгэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, үр дүнг танилцуулах.

2. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийж, холбогдох хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлж, хэлэлцүүлэхээр тогтсугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хороо (Б.Баярбаатар)-нд даалгасугай.

ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.БАЯРБААТАР



TУС3761 9023051390 9087484